

ЧИНГИС ХААН БА МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

*Л.Оюунгэрэл**

Судлаачдын сонирхлыг ямагт татаж байдаг асуудал бол Монголын Нууц Товчооны зохиогчийн тухай асуудал билээ. Түүнээс гадна зохиолыг бичсэн цаг хугацааны талаар эрдэмтэд өөр өөр саналтай байдаг. Гэхдээ Монголын болон гадаадын судлаачдын ихэнх нь 1228-1240 оны хооронд бичсэн хэмээн үзэж байна. Монголын эрдэмтэн Шагдарын Бира 70-аад оны эхээр бичихдээ: “Нууц Товчоог анх түрүүн хаан тэргүүтэй “Алтан ураг”-ийн шилдэг төлөөлөгчид идэвхтэй оролцож бичиглэн үлдээжээ” гэсэн байдаг.¹ Японы монгол судлаач Ш.Озава 1998 онд мөн ийм дүгнэлтэнд хүрчээ.²

Нууц Товчооны зохиогчийн тухай судалгааг нэгд, арван гуравдугаар зууны үеийн Монголын бичиг соёлын хөгжлийн ерөнхий төлөв байдал, хоёрт, түүхийн тодорхой үйл явдлуудыг өөр өөр эх сурвалжуудад хэрхэн тусгасныг харьцуулсан харьцуулалт, гуравт, зохиолын бүтэц, найруулга зүй ба хэл зүйн зарим асуудалд хийсэн дүн шинжилгээнээс харахад дээрх санал үндэслэлтэй санагдаж байгаа юм. Тиймээс судалгааны явцад гарсан зарим дүгнэлтийг тоймлон авч үзье.

Монголын бичгийн соёлын хөгжил

Монголын зарим эрдэмтэн монгол бичиг үүссэн хугацааг МЭ-ний VI-VII зуунд гэж үзэж байгаа билээ.³ Тэгвэл арван гуравдугаар зууны эхэн үед монголчууд бичгийн соёлоо сэргээн хөгжүүлсэн гэлтэй. Академич Ш.Нацагдорж бичихдээ: “Чингисийн аугаа их гавьяа бол монгол үндэсний бичиг зохиох явдлыг санаачлан ард түмнээ бичиг үсэгтэй болгосон явдал” гэжээ.⁴

Монголын эзэнт гүрний үед монгол бичгийн соёл хөгжиж ирсэн түүхийг бүрэн судлаагүй байгаа билээ. Гадаадын монгол судлалд Чингис хааны үед монголчууд бичиг үсэггүй байсан гэсэн дүгнэлт давамгайлж байгаа. Харин Японы монгол судлаач Х.Окада 2004 оны 9 сард Улаанбаатар хотод болсон “Монголын эзэнт гүрэн (үүсэл, цэцэглэлт, задрал)” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр Монголын Нууц Товчооны талаарх илтгэлдээ “Монгол овог аймгууд 1194 он хүртэл бичиг үсэггүй байсан бөгөөд Тэмүжин Хэрэйдийн Ван хаантай хамтарч ажилласан 1194-1196 оноос бичигтэн болсон ба түрэг хэлээр ярьж бичдэг байсан байж магадгүй” гэжээ.⁵ Энэ таамаглалыг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд эх сурвалжуудад байгаа мэдээллийг харьцуулан судлахад ямар ч байсан Монголын нэгдсэн төр байгуулагдах үеэс буюу 1206 оны үеэс монголчууд уг гарал, төр улсынхаа түүхийг бичиж эхэлжээ. Энэ талаар Чингис хаан зарлиг болгохдоо: “Гүр иргэний

* Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хувь хувилсныг, зарга заргалсныг, хөх дэвтэрт бичиг бичиж, дэвтэрлэж, ургийн урагт хүртэл Шигихутугийн надтай зөвшиж ёслож, хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү егүүтэгтүгэй” гэсэн билээ.⁶ Харин бидний сонирхож байгаа асуудал бол МНТ-г бичихэд хэн хэн оролцсон байж болох, мөн Чингис хаан өөрөө хэлж ярьж бичүүлсэн эсэх зэрэг юм. И. де Рахевилз МНТ-ны 269-р зүйлд “...хан эцгийн минь биеийн дэргэд явж байсан өмч түмэн хэшигтэнийг нь Цагаадай ах Толуй хоёр Өгөдэй хаанд дагуулав”⁷ гэж “хан эцгийн минь” гэж зохиогч өөртөө хамааруулан бичсэнийг иш үндэс болгож уг зохиолыг бичихэд Шигихутуг оролцсон гэж дүгнэсэн нь үнэмшилтэй санагдаж байгаа билээ.

Судалгаанаас харахад МНТ-г бичихэд Шигихутуг оролцсоноос гадна Чингис хаан өөрөө хэлж ярьж бичүүлсэн гэсэн дүгнэлт хийж болмоор байна. Оросын нэрт эрдэмтэн Л.Гумилев бичихдээ: “Нууц Товчоонд гол баатрын хэлсэн үгийг гуравдугаар биенд өгүүлэх аргыг хэрэглэсэн нь зохиогчийн их юм уншсан, өргөн мэдлэгтэйг харуулж байна” гэжээ.⁸ Үүнийг асуудалд хандах европын буюу суурин соёл иргэншлийн хандлага гэлтэй. Гэтэл зохиогчийн тухай асуудлыг бид нүүдэлчдийн соёлын өвөрмөц логикийнх нь үүднээс авч үзэх ёстой болов уу? Өөрөөр хэлбэл аман мэдээллийн уламжлалтай нүүдэлчдийн хувьд уг зохиолыг бичгээр тэмдэглэсэн хүнийг нь биш, харин тодорхой мэдээлэл, үзэл баримтлал гаргасан (өөрөөр хэлбэл бодож сэтгэснийг нь) жинхэнэ зохиогч гэж үзэх үндэстэй. Ийм хандлагыг баримталвал Нууц Товчоо зохиолын үзэл баримтлалынх нь зээн хэн бэ? гэсэн асуулт гарч байгаа билээ. Хэдэн зууныг дамжсан Чингис хааны ургийн түүх, тэдний нөхөр ба дайсан хэн байсан, “дэлхий дахиныг засан тохинуулахын” төлөө явуулсан дайн байлдаанд хэн хэн ямар гавъяа байгуулсан зэрэг зохиолын гол үзэл баримтлал Чингис хааны бодол санаа, хүсэл эрмэлзлийн дагуу бичигджээ. Тэгвэл энэ бүгдийг өөрөөс нь илүү хэн ч үл мэдэх билээ. Хэрэв Чингис хаан өөрөө хүүрнэн ярьж бичүүлсэн бол хаанд тийм боломж, цаг зав байсан уу? хэзээ, ямар нөхцөлд хүүрнэн ярьж байсан байж болох вэ? гэсэн асуулт бас гарч ирнэ. Чингис хааны үйл ажиллагааг он оноор судлахад цаг хугацааны хувьд чухам Хорезмын аян дайны үед тийм боломжтой байсан мэт. Тийм учраас Хорезмын аян дайны үеийн хааны цэрэг, байлдааны болон ялангуяа оюуны үйл ажиллагааг нь илүү дэлгэрэнгүй авч үзье.

Хорезмын дайны тухай гол эх сурвалж – Жүвейнийн зохиолд монголчуудын бичиг үсгийн талаар

Хорезмын аян дайны явцад монголчууд бичиг үсгийг хэрхэн ашиглаж байсан тухай мэдээг Жүвейнийн “Ертөнцийг байлдан дагуулагч” номонд тодорхой өгүүлжээ. Жүвейни 1252 оны 5 сараас 1253 оны 9 сар хүртэл Хархорумд байхдаа алдарт номоо бичсэн бөгөөд Нууц Товчооны анхны монгол хэл дээрх эх сурвалжийг үл тооцвол

Чингис хааныг бие барснаас хойш 25 жилийн дараа буюу үйл явдалд нэн ойр байсан хүн юм. Монголчуудын бичиг үсэг хэрэглэж байсан тухай Жүвейнийн дурьдаж буй бүх мэдээллийг багцалж үзвэл;

1. Тэд монгол хэлээр уйгар үсгээр бичдэг байсан,
2. Ал-тамгыг уйгар үсгээр бичсэн;
3. Элч нарт захидал өгч илгээдэг байсан;
4. Өгөдөйд хаан ширээ залгамжлуулахыг ах дүү нар нь зөвшөөрч бичгээр бичсэн;⁹
5. Чингис хаан султаанд захидал илгээсэн¹⁰
6. “Чингис хаан зарлигт бичсэн” гэжээ.¹¹ (Энд хаан өөрөө бичсэн гэж ойлгогдож байна)

Жүвейни хэд хэдэн удаа монгол бичмэл сурвалжуудын тухай өгүүлж “тэдний бичсэн юм энд хоорондоо зөрж байна”,¹² эсвэл өөр нэг газар “нэг өгүүлэлд бичсэнээр”¹³ гэж иш татжээ. Жүвейнийн ашигласан монгол эх сурвалж Нууц Товчооны анхны эх ч байсан байж магадгүй гэдэг нь жишээлбэл адуучин Бадай, Хишлиг нарын тухай өгүүлж буй тэр хэсгээс тод харагдаж байна. Тийм учраас тэр хэсгийг Нууц Товчоо, Лу. Алтан Товч зэрэг монгол эх сурвалжуудтай харьцуулж үзье. Ван хан шөнө дөлөөр довтлох гэж буй тухай сонсож Чингис хаанд адуучин Бадай, Хишлиг нар хэл хүргэсний дараа болсон үйл явдлын талаар Нууц Товчоонд өгүүлэхдээ: “Чингис хаан тэдний үгэнд итгэж” тэр шөнөдөө дэргэдэх бүх итгэлтэй хүмүүстээ хэл өгөөд, хөнгөлөн юм хүмээ орхиж, буруулан мөн шөнө хөдлөв. Маргааш нь Хар халзан элст хүрч үдлэн буув... тэндээс агтсаа бариулаад, ачаалж мориллов” гээд (зүйл 170) улмаар “Балжуна нуурт буусан тухай” өгүүлж байна. (зүйл 182) Лу. Алтан Товч-д яг ингэж өгүүлсэн байгаа. Тэгвэл Жүвейни чухам энэ үйл явдлын талаар бичсэн бөгөөд тэр ч байтугай монгол эх сурвалжуудад байхгүй мэдээллийг, тухайлбал “1202-3 оны хавар Ван хаантай Балжуна гэдэг газар тулалдаж ялсан” гэж тодруулжээ.¹⁴

Хорезмын аян дайн: монгол бичиг, түүх бичлэг,
газар зүйн судалгаа хөгжсөн нь

Монголын Нууц Товчооны 254-264-р зүйлд Хорезмын аян дайны тухай өгүүлж байгаа бөгөөд тэдгээрт дүн шинжилгээ хийхэд энэ хэсгийг дайны явцад бичсэнээс гадна Чингис хаан өөрөө шууд хэлж бичүүлсэн гэсэн бодол төрдөг. Энэ нь дайны үеэр Чингис хаан бичиг соёл, түүх бичлэг, газар зүйн мэдлэгийг хэрхэн ашиглаж байснаас харагддаг.

Хорезмыг эзлэх явцад Чингис хаан дайн байлдааны стратеги боловсруулаад зогсохгүй эзэлсэн хотуудыг төвхнүүлэхэд анхаарч, эзлэгдсэн газар орон, хүн амын талаар судлуулж монгол бичиг, түүх бичлэг, газар зүйн судалгаа энэ бүс нутагт хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэжээ. Хаанд цаг хугацааны хувьд ч тийм боломж байжээ.

Хорезмыг үндсэндээ 1219-1222 онд байлдан дагуулж дууссан билээ. Чингис хаан 1221 оны 11 сард Инд мөрний эрэг дээр Желал-ад-Дины гол хүчийг буцлохисноос хойш дайн байлдааны үйл ажиллагаанд биечлэн бараг оролцоогүй бөгөөд нутаг буцах хүртлээ харьцангуй чөлөөтэй дөрвөн жил байжээ. Хаан энэ хугацаанд зөвхөн дайн байлдааны биш, оюуны олон төрлийн үйл ажиллагаа өрнүүлжээ:

1. Юуны өмнө өрнө, дорно зүгт илгээсэн Зэв, Сүбээдэй, Бала нараас ирэх мэдээг ихэд хүлээж байсан тухай сурвалжуудад өгүүлдэг. Тэдний тагнан турших аяллын мэдээ цаашдын цэрэг, байлдааны стратегийг боловсруулахад их чухал байсан нь үүнээс илт харагдаж байгаа билээ. Хаан Хорезмын аян дайны үр дүнг тооцож цэрэг байлдааны цаашдын стратегиа төлөвлөж байсан бололтой. Байлдан эзэлсэн хотуудыг нямбай бүртгэж авдаг байжээ. Оросын эрдэмтэн Бартольдын бичсэнээр Чингис хаанаас Герат хотын захирагч Рукн ад-Дин Карт (Курт)-д монголчуудын эзэлж аваад байгаа бүх газар нутаг, буулгаж ялсан Хорезмын шахын цэргийн жанжнуудын дэлгэрэнгүй жагсаалт бүхий бууж өгөхийг тулган шаардсан бичиг байсан ба харамсалтай нь хадгалагдаж үлдээгүй ажээ.¹⁵ Ийнхүү дайны үеэр захидал бичгээр харилцаж байсан нь харагдаж байгаа бөгөөд монголчууд бичгийн соёлыг дайн, байлдааны зорилгоор сайн ашиглаж чаддаг байжээ. Мөн 1224 онд Йакут ал-Хамави хэмээх арабын газар зүйч газар зүйн толь бичиг хэвлүүлж тэнд Зэв, Сүбээдэй нарын хазар, алан, орос, Кипчакийн тал, Булгаруудын нутаг дэвсгэрт дайран орсон тухай өгүүлж газар орны тухай бичсэн ажээ.¹⁶

2. Хорезмыг байлдан дагуулсаны дараа нутгийн засаг захиргааг томилж ажиллуулах явцад бичгийн ажил чухал үүрэгтэй болсон нь мэдээж. Монголчуудын томилсон даругачи нар хүн амыг тоолох, цэрэгт татах, өртөө зохион байгуулах, олз, бэлэг сэлтийг бүртгэх, төв засгийн газарт буюу хаанд мэдээлэл цуглуулах зэрэг үүрэгтэй байв. Нутгийн хүн амтай шууд харилцах, бичиг цаасны ажлыг нутгийн иргэд, урьд итгэлтэйгээ харуулсан уйгар, кидан зэрэг түшмэд гүйцэтгэж, харин бодлогыг нь монголчууд өөрсдөө барьж байсан болов уу?

1222 онд Чингис хаан Хятадын гүн ухаантан Чань Чунь бумбыг урьж уулзаж ярилцсан ба “яриаг нэгд нэгэнгүй уйгар үсгээр тэмдэглэж авахыг” зарлиг болгожээ.¹⁷ Хаан бумбын шашинт ламаас юуны өмнө эм залах хүсэлтэй байснаас гадна Хорезмыг байлдан дагуулсан түүхээ Хятад оронд дуулгах, Хорезмын аян дайны мэдээг бичүүлж үлдээх хүсэлтэй ч байсан байж болно. Ямар ч байсан Чингис хааны Чан Чунь бумбатай уулзсан уулзалтын тухай тэмдэглэл XIII зууны монголчуудын түүхийн талаарх ховор эх сурвалж болж өнөөг хүртэл хадгалагдан үлджээ. Түүнээс гадна кидан Елюй Чуцай Хорезмын аян дайнд Чингис

хааныг дагалдан явсан газар орныхоо газар зүй, байгалийн байдал, нутгийн зан заншил дайны тухай “Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх ном бичиж хожим 1228 онд хэвлүүлжээ. Елюй Чудай эл номоо Хорезмд байхдаа бичсэн байж магадгүй.

Чухам Хорезмын аян дайны явцад бас дараахан нь Чингис хаан өрлөг жанжин, цэрэг эрсийнхээ баатарлаг гавьяа, хойч үеийнхнийхээ дагаж мөрдөх хууль цаазад ихэд анхаарч байсан тухай сурвалжуудад дурьддаг. Хаан “1225 онд засаг билгийг нийтлэх зарлиг буулгасан” гэж Рашид-ад-Дин бичсэн¹⁸ бол Плано Карпини аян замын тэмдэглэлдээ бас энэ тухай тэмдэглэж “Чингис хаан 1225 оны зун нутагтаа ирээд олон тооны хууль зарлиг гаргасан”¹⁹ гэжээ. 1225-1228 онд Монголд ном дэвтэрлэж хэвлэн нийтлэх ажил хэвшиж тогтмолжсон бололтой.

Нууц товчоонд Чингис хааны цэрэг, улс төрийн үзэл баримтлалыг тусгасан онцлог

Монголын Нууц Товчооны ихэнх зүйлд Чингис хааны яриа, зарлиг, хүмүүсийн талаар хэлсэн үг, байлдааны стратегийн тухай өгүүлж байгаа билээ. Тухайлбал Чингис хааны зарлиг, тушаал Нууц Товчооны 153-р зүйл (1202он)-ээс эхэлж улмаар зүйл 156, 187, 191(192, 193, 202, 203, 204, 221, 222, 223, 224-234, 235, 236, 237, 238, 240-д оржээ. Нууц Товчоонд Чингисийн зарлиг, тушаалуудыг тэр чигээр нь хуулан бичсэн гэлтэй.

Нууц Товчоонд Чингис хааны цэрэг-улс төрийн үзэл баримтлал тусгагджээ. Энэ нь Хорезмын аян дайны тухай хэсгээс нэн тод харагддаг. Тийм учраас Хорезмын аян дайны тухай өгүүлсэн Нууц Товчооны нийт 11 зүйлд байгаа мэдээлэлд агуулгын талаас дүн шинжилгээ хийхийг оролдъё:

1. Хорезмыг эзэлж авах болсон шалтгаан;
2. Чингис хаан жанжнууд ба хөвгүүдээ аль хот руу илгээсэн
3. Чингис хааны өөрийнх нь явсан газрын чиглэл,
4. Сүбээдэй, Зэв, Бала нарын тагнан турших аяны чиглэлүүд
5. Хойч үеийнхэндээ сургамж болгох гэсэн үйл явдлуудын тухай өгүүлж байна.

Бичсэн арга хэлбэр бүгд Чингис хааны бодол санаа, үзэл баримтлал, зарлиг, шийдвэрийн үүднээс бичжээ. Зохиолын энэ хэсэгт Чингис хааныг оруулаад нийт 26 хүний нэр дурьдагдаж байгаа бөгөөд тэдний үйл ажиллагааг хааны өгсөн зарлиг, тушаалыг хэрхэн биелүүлсэн үүднээс хандаж бичжээ. Харин Чингис хааныг онцолж магтан дуулсан зүйл огт алга байна. Энэ нь монголчуудын түүх бичлэгийн онцлог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд бусад улс орон, жишээлбэл хаадын түүхийг бичдэг европын уламжлалаас тэс өөр юм.

Хорезмыг байлдан дагуулсан үйл явцыг Нууц Товчоонд тусгасан байдлыг бусад эх сурвалжуудтай, ялангуяа тухайн цаг үед нь амьдарч,

бүр зарим тулалдаанд оролцож явсан Жужани, хожим Рашид-ад-Дин ба Алтан Товч-д хэрхэн тусгасныг харьцуулж үзээд доорх дүгнэлтүүдийг хийж болохоор байна:

1. Хорезмын байлдан дагуулалтын явцад олон тооны том, жижиг хотыг эзэлж авсан боловч Нууц Товчоонд тэдгээрээс хамгийн хүнд, урт удаан хугацаанд бүслэлт хийж байлдан дагуулсан Ургенч зэрэг цөөн тооны хотыг л тусгажээ.

Үүнийг эцсийн ялалтыг авчирсан шийдвэрлэх тулалдаануудыг л дурссан байна. Үүнийг юу гэж тайлбарлаж болох вэ? гэвэл гагцхүү байлдааны стратеги, явц, ялалтад төлөвлөгөө, арга замыг үзэл баримтлалынх нь хувьд боловсруулсан, байлдааны нийт үйл явцад хяналт тавьж тактик боловсруулж хэрэгжүүлж удирдаж байсан тэр хүн л хамгийн сайн мэдэж, бас хэлж ярьж бичүүлсэн санагдаж байна. Тэр хэн бэ? гэхлээр мэдээж хэрэг Чингис хаан өөрөө болж таарч байна. Зөвхөн хааны мэдэх ёстой байлдааны стратегийг хэрхэн дүрсэлсэн байдлаас нэн тод харагдаж байна. Зарим тодорхой үйл явдлыг хэрхэн тусгасныг энд жишээ болгож болох юм. Нууц Товчооны 257-р зүйлд Зэв, Сүбээдэй, Тохучар гурвыг тулалдаанд илгээсэн тухай өгүүлж байгаа. Тэд “балгасыг үл хөндөх” тушаалтай байжээ. Хааны энэ тушаал байлдааны тактикийн хувьд их чухал байжээ; учир нь Герат хотын эзэн Мелик хаанд бууж өгсөн тохиолдолд дээрэм тонуул хийхгүй гэж амалсан Чингис хааны бичгийг өгсөн байв.²⁰ Гэтэл Тохучар хан Мэлигийн хязгаар балгасыг довтолж дээрэмдэн тариачдыг олзолжээ. Түүний эл үйлдэл цэргийн ажиллагааг хүндрүүлсэн учраас Нууц Товчоонд тэмдэглэн үлдээсэн гэж үзэх үндэстэй. (МНТ, зүйл 257) Харин энэхүү ажиллагааны хор холбогдлыг байлдааны тактикийг гардан удирдаж байсан хаан өөрөө л хамгийн сайн мэдэж байсан гэлтэй.

2. Чингис хааны явсан газрын чиглэлийг Нууц Товчоонд хэрхэн тусгасан байдлыг мөшгин судлахад бас чухам хааны явсан газруудыг, хааны байр сууринаас бичсэн нь бас ажиглагдаж байна. Нууц Товчоонд дурьдсанаар Чингис хаан Бадахшан (зүйл 257), Отрар (зүйл 258), Самарканд (зүйл 259), Бухара (зүйл 259) хотыг эзэлсэн тухай өгүүлсэн ба Нууц Товчооны 257-р зүйлд өгүүлсэнээр “Чингис хаан Бэдхэгсэнийг дахиулж Эх горхи, Гүүн Горхид хүрч Бараан хээрт буув” гэжээ. Мөн 259-р зүйлд “Алтан горхины нуруунд зусав” гэж хааны зуссан газрын чиглэлийн талаар хоёр удаа дурьдаж байгаа. Харин бусад эх сурвалж ба гадаадын ба монголын эрдэмтэдийн хийсэн судалгааг өөр хооронд нь харьцуулж 1221 онд Чингис хааны явсан газрыг тодруулахад:

1221 оны эхээр Термез хотоор дайрч Нууц Товчоонд дурьдагдаж байгаа Бэдхэгсэний (Бадахшан)-ий нийслэл Балх хотод хүрч улмаар Таликан (тэнд 7 сар байсан), Гурзиван (1 сар байсан), Андараб (1 сар),

Перванд (Бараан хээр) (тэнд 3 сар болсон) очжээ. Үүнээс харахад Нууц Товчооны 257-р зүйлд Чингис хааны хаанаас хаа хүрсэн гол чиглэлийг л заасан байна. Энэ нь юу өгүүлж байна вэ? гэвэл Хорезмын аян дайны тухай хэсгийг үйл явдлыг сайн мэдэх хүн хэлж бичүүлсэн гэсэн дүгнэлтийг улам баталгааж байна. Үүний зэрэгцээ ерөөсөө Чингис хааны хэлсэн ярьсан, хийсэн, явсан газрыг тухайн тэр үед нь шууд тэмдэглэж байсан гэлтэй. Тэмдэглэхдээ илүү нарийвчлан бичиж байсныг бусад эх сурвалжууд нотолж байна. Жишээлбэл 1221 онд Чингис хаан Андараб гэдэг жижиг хотоор дайрсан тухай мэдээллийг тун саяханаас мэдэх болсон юм. 1985 онд афганистаны эрдэмтэн Султан шах Хомамын илрүүлсэн перс хэл дээр бичсэн “Кабулын сударт” (зохиогчийн нэр нь үл мэдэгдэх энэхүү судрыг Хомам 15-р зуунд бичсэн болов уу? гэж таамаглаж байна) Хорезмын аян дайны тухай бусад эх сурвалжуудад байдаггүй зарим нэгэн мэдээ, түүний дотор Чингис хаан 1221 оны хавар Таликанаас Бамиан орохдоо Андараб²¹ хотоор дайран өнгөрсөн гэжээ. Энэхүү мэдээ үнэн болох нь Бартольддын хийсэн судалгаагаар бас нотлогдож байгаа юм.

Үүнээс бид ямар дүгнэлт хийж болох вэ? гэвэл Нууц Товчооны анхны, монгол хэл дээрх эх сурвалжид үйл явдлыг илүү дэлгэрэнгүй өгүүлсэн бололтой. Үүний нэг илрэл бол эх сурвалжууд дахь материал зарим тохиолдолд өөр өөр байгаа ба тэдгээрийг Нууц Товчоонд хэрхэн тусгасныг авч үзэхэд илүү товчилсон, тэгэхдээ улс төр, цэргийн үзэл баримтлалын хувьд ач холбогдол бага мэдээллийг хассан нь ажиглагдаж байна. Жишээлбэл Хорезмын аян дайнаас буцах замдаа Чингис хааныг Хубилай, Хүлэгү хоёр угтаж авсан тухай мэдээ Нууц Товчоонд байдаггүй; тэгвэл энэ тухай Алтан Товчид “Явсан хөвгүүдээс хамгийн түрүүнд Хубилай хөвгүүн хүрч ирж, сартуулын олзноос Хубилай хөвгүүнд ихийг нь өгөв” гэжээ. Энэ үйл явдал Алтан Товч-д өгүүлсэнээр долдугаар онд Хар Зайр нэрт газар болсон ба харин Хүлэгүгийн тухай огт дурьдаагүй ажээ. Тэгвэл Кабулын сударт (бас өөр эх сурвалжуудад ч энэ тухай бичсэн байдаг) бичихдээ: “1224 онд Чингис хаан долоон жилийн дараа хатад, хөвгүүдтэйгээ уулзаж ихэд баяртай байсан” гээд арван настай Хубилай, есөн настай Хүлэгү нар хааныг угтаж авах ёслолын үеэр анх удаа ан авласан тухай өгүүлжээ.

Нууц Товчоонд ач хөвгүүд - Хубилай, Хүлэгү нарын тухай дурьдаагүй ч харин Хорезмын аян дайнд хөвгүүдээс нь хамгийн сайн байлдсан Тулуйн тухай 258-р зүйлд Герат, Нишапур ба бусад хотыг эзлүүлэхээр илгээсэн тухай, мөн 259-р зүйлд өгүүлсэн бол Зүчи, Цагаадай, Өгэдэй нарыг “чамдаж” “гурван өдөр эс уулзав” гэж 260-р зүйлд бичсэн билээ. Хөвгүүдийнхээ талаар үнэлгээ өгсөн эдгээр зүйлийг Чингис хааны өөрийнх нь оролцоогүй бичсэн гэхэд үнэмшилгүй. Тэгээд

ч түүхийн бусад сурвалжуудад Тулуй бусдаасаа илүү байлдаж хааны зарлигийг биелүүлж байсан тухай дурьддаг гэдгийг тооцвол Хорезмын аян дайны тухай өгүүлсэн бүхий л зүйлүүдийг Чингис хаан өөрөө хэлж ярьж, бас хянаж бичүүлсэн гэлтэй.

Нууц товчоо зохиолд Чингис хааны сэтгэл хөдлөлийг
илэрхийлсэн арга хэлбэр, биеийн төлөөний үгийн хувирал

Лувсанданзан Алтан Товчийг бичихдээ Нууц Товчооны анхны монгол эхийг ашигласан гэж эрдэмтэд үздэг. Тэгвэл Нууц Товчоо, Алтан Товч-д байгаа зөрүүтэй баримтуудыг гаргаж, тэдгээрийг өөр хооронд нь харьцуулах замаар илүү анхдагч мэдээ нь эртний Нууц Товчооны анхны эх ямар байсан талаар таамаглал дэвшүүлж болох ба эх сурвалжууд дахь зөрүүг харьцуулах замаар ямар учир шалтгаанаар засвар орсон тухай ч бас тодорхой санаа хэлж болмоор ажээ.

Нууц Товчооны зүйл 146-д гардаг үйл явдлыг Алтан Товчд өгүүлэхдээ: “Чингис хаан сонсоод хатирч хүрч, бууж тэврэлдэв. (Торхан шарын охин Хадаантай-Л.О) Эрийг нь бидний цэргүүд алах болуузай хэмээж тэд иргэнийг илгээж эрийг нь аврав” гэжээ. Энд “хэмээж” гэсэн үйлийн эзэн Чингис гэдэг нь тодорхой байна. Харин энэ үйл явдлыг Нууц Товчооны 146-р зүйлд бичихдээ: “Би Хадаан нэртэй. Эрийг минь энд цэргүүд барьж алах гэж байна” гэхэд “Чингис хаан энэ үгийг сонсч хатируулан хүрч, мориноос бууж, Хадаантай тэврэлдэв. Эрийг нь манай цэргүүд урьд алчихжээ” (МНТ, зүйл 146, х. 55) Энэ харьцуулалтаас нэгд, Нууц Товчооны анхны эхийг үйл явдлын үнэн мөнийг тодруулж бичжээ; хоёрт, Алтан Товчийн анхны монгол эхэд (тэр нь Нууц Товчоог бичихдээ ашигласан монгол хэл дээрх анхны эх байж болзошгүй) Чингис хааны хэлсэн үгийг хэлсэн даруйд нь бичиж авсан ба харин хожим дээр өгүүлсэн Хадааны эр нөхөр нэгэнт алагдсан байсан учраас залруулж бичжээ гэж үзэж болохоор байна. Нууц Товчоог Алтан Товчтой харьцуулж үзэхэд үйл явдлыг тодруулж зассан ийм засвар хэд хэд байна.

Монголын Нууц Товчоо зохиолыг Чингис хаан өөрөө хэлж ярьж бичүүлсэн гэсэн таамаглал ялангуяа хааны дотоод бодол санаа, сэтгэл хөдлөлийг харуулсан дүрслэлүүдэд үнэмшилтэй санагдаж байна.

Зохиолыг бичихэд Чингис хаан шууд оролцсон гэсэн сэтгэгдэл хааны сэтгэл хөдлөлийг харуулсан дүрслэлүүдээс бас ажиглагдаж байгаа юм. Жишээлбэл 132-р зүйлд өгүүлсэн Бэлгүтэй, Бүри бөх хоёрын маргаанд Чингис хааны хандсан хандлагыг гаргасан зүйлийг Алтан Товчынхтой харьцуулсан харьцуулалтаас харж болно. Алтан Товч-д дээрх үйл явдлын талаар өгүүлэхдээ: “Чингис хаан сүүдэрт сууж, хурим дотроос үзэн гарч ирээд өгүүлсэн нь: Хэнд ингэж цавчигдав хэмээхүйд Бэлгүтэй: “...Миний төлөө ах дүү нар муудуузай” гээд “Бэлгүтэй төдий ятгаваас үл болон, Жүрхэнийг ялж, Хорижин хатан, Хууржин хатан хоёрыг булааж авав” гэжээ.

Нууц Товчоо зохиолд биеийн төлөөний үг хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглая:

Зүйл 131-д “Тэр хуримыг манай талаас Бэлгүтэй засаад...” гэжээ. Энд “бид” гэсэн биеийн төлөөний үг Чингис хааны байр суурийг илэрхийлэхэд хэрэглэгджээ. Судалгааны хувьд анхаарууштай зүйл бол эх бичигт хааны байр суурийг ихэнх тохиолдолд шууд яриа, эсвэл зарлиг, шийдвэрийн хэлбэрээр илэрхийлж байгаа билээ. Жишээлбэл зохиолын 153, 156, 187, 191, 192, 193, 202, 203, 204, 221, 222, 223, 224-234, 235, 236, 238, 240 зүйлүүдэд Чингис хааны засаглан хэлсэн зүйлүүд тэр чигээрээ тусгагджээ. Харин дээр бидний жишээ болгосон цөөн зарим тохиолдолд биеийн төлөөний үгийн хувирлаар тухайн үйл явдалд үйлийн эзний хандах хандлага ажиглагдаж байна. Дээрхтэй ижил өөр нэг жишээ татъя. Зохиолын 142-д үйлийн эзнийг биеийн төлөөний үгээр хэрхэн илэрхийлсэнийг авч үзвэл үйлийн эзэн, зохиогчийн байр суурь давхцаж байгаа бөгөөд тэдгээрийн хамаарлыг гаргавал:

1. Чингис хаан, Алтан, Хучар, Даридай гурвыг манлайд явуулав...
2. Бидний манлай Алтан, Хучар, Сэнгүнтэн Эдүхүнд хүрч бууя хэмээлдэж...
3. Бидний манлай тэдэнтэй уншилдаж (өгүүлэлдэж) нэгэн хүрээ болж...
4. Чингис хаан Ононы зүг Тайчуудын Нагачу баатрыг нэхэв.
5. Чингис хаан хүрээд Тайчуудтай хатгалдав.
6. Чингис хаан тэр хатгалдсанд хүзүүндээ шархдаж...
7. Чингис хааны дотор сэргэж өгүүлсэн нь:...

Эндээс харахад 2, 3-т байгаа “бидний манлай” гэсэн үйлийн эзэн 4-7-дшүүд “Чингис хаан” гэсэн үйлийн эзэн болж хувирч байгаа бөгөөд зохиолд “бид” гэсэн биеийн төлөөний үгийг Чингис хаанд хамааруулан хэрэглэжээ.

Нууц Товчоо зохиолын 140-р зүйлд: “Бүри бөх үл ялагдах хүн унаж өгөв. Бэлгүтэй арай хэмээн мөрлөн дарж саарь дээр нь гараад Чингис хааныг хяламхийж үзэхүйд Чингис хаан бэвхийгээ зуув...” гэсэн нь энэхүү барилдааныг нүдээрээ харсан хүн өгүүлж бичүүлсэн, эсвэл зохиолыг бичсэн хүн үйл явдлыг өөрөө харсан мэт дүрсэлжээ.

Үүнтэй холбоотой Нууц Товчоог 1228 онд бичиж дуусгасан гэсэн И.де Рахевилз ба бусад судлаачдын саналыг зөв гэж үзэж Нууц Товчоо зохиолын Чингис хааны тэнгэрт хальсанаас хойших үйл явдлуудыг тусгасан 269-282-р зүйлд дүн шинжилгээ хийхэд түрүүчийнхээсээ үзэл баримтлал, өнгө аяс, биеийн төлөөний үгийг хэрэглэсэн байдал (гол төлөв гуравдугаар биенд) тэс өөр байгаа нь тод харагдаж байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Shagdaryn Bira, Mongolian Historical Writing from 1200 to 1700, Western Washington University, p. 21
2. Ozawa Shigeo, Mongol-un niyuca tobciyan-u yirtincu. Kokeqota: Obor Mongyol-un Arad-un Keblel-un Qoriy, 1998, p. 122
3. Ц.Шагдарсүрэн, К вопросу о происхождении монгольского письма, ОУМЭ-ийн III их хурал, III боть, УБ, 1978, 286-290
4. Ш.Нацагдорж, Чингис хааны цагид, УБ, 1991, х. 191
5. H.Okada, The real figure of Chinggis Khan NOT based on the text of Mongghol-un Nighucha Tobchaghan, p. 3
6. Монголын Нууц Товчоо, 2005, зүйл 203, х. 103
7. мөн тэнд, х. 143
8. Л.Н.Гумилев, В поисках вымышленного царства, М, 1992, с. 103
9. The History of the World -Conqueror by Ata-Malik Juvaini, translated by J.A. Boyle, Manchester University Press, 1958, p. 183
10. мөн тэнд, х. 79
11. мөн тэнд, 121
12. мөн тэнд, х. 37
13. мөн тэнд, 53
14. мөн тэнд, 37
15. В.В.Бартольд, Чингиз-хан и монголы, Сочинения, том 1, М, 1963, с. 528
16. Христианский мир и “Великая Монгольская Империя”, Материалы францисканской миссии 1245 года, Санкт-Петербург, 2002, с. 331
17. Чань Чунь Бумбын Өрнө зүгт зорчсон тэмдэглэл, УБ, 1997, орч. Н.Ариунгуа, ред. Ш. Нацагдорж, х. 4
18. Рашид-ад-Дин, сборник летописей, М, 1952, том 1, книга вторая, с. 230
19. Путешествия в восточные страны Плано Карпини и Рубрука, М. 1957, с. 43
20. В.В.Бартольд, Сочинения, том 1, М, 1963, с. 511
21. S.Sultan Shah Nomam, A brief report on the Kabul Manuscript, ОУ Монголч эрдэмтний V их хурал, №3, УБ, 1992, х. 288